



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/211

Булган сум

“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2017 оны 32 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2024 оны А/35 дугаар тушаал, Засгийн газрын Батлан хамгаалах зарим чиг үүргийг Булган аймагт төлөөлөн 2024 онд хэрэгжүүлэх гэрээний 1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалт бүртгэлийг 2024 оны 03 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 11-ний өдрүүдэд, Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалтыг 04 дүгээр сарын 01-нээс 08 дугаар сарын 16-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Цэргийн штаб (хурандаа Ч.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

2.“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтад хамрагдах оюутан, суралцагчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах нарийн мэргэжлийн эмч нарын комисс гарган ажиллуулахыг Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг)-т, цэргийн ерөнхий бэлтгэл сургалтын хөтөлбөрийн дагуу хичээлийн байр, техник хэрэгслээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д, мэргэжлийн бэлтгэл сургалтыг зохион байгуулахад хээрийн сургалтын төвд дэмжлэг үзүүлж ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д тус тус үүрэг даалгасугай.

3.“Оюутан цэрэг”-т цэргийн мэргэжил олгох сургалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан 2024 оны 3 дугаар улиралд багтаан дүн мэдээг танилцуулахыг Цэргийн штаб (хурандаа Ч.Энхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ